



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 446

Улаанбаатар хот

“Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК-ийн  
хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 41.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ын 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК-ийн гаргасан 12 сарын хугацаатай, нэг бүр нь 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,650 ширхэг, нийтдээ 3,650,000,000 /гурван тэрбум зургаан зуун тавин сая/ төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай өрийн бичгийг бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмаар хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК /Н.Ундрах/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

050488